ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Номгон сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/105/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn
Аудитор: П.Санчиргарав
Утас: 70533552 Цахим хаяг: Sanchirgaravp@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 217

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОМГОН СУМ 14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.АЛТАНТУЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Номгон сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын эд хариуцагч 69,114.4 мянган төгрөгийн хүнсний тайлан гаргаагүй, нягтлан бодогч материалын тайлангийн зарцуулалтыг бөөн дүнгээр тайлагнасан, хагас жилийн тооллого хийгээгүй, хүүхдийн хоолны зардлыг норм нормативаас 2,288.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх бэ үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 9,450.0 мянган төгрөгийн бараа материал, 20,550.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийлүүлснийг бүртгэлд тусгасан байна.

4626050346

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 60,069.8 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 73,699.5 мянган төгрөгийн нутгийн дэмийн урамшуулал, 17,920.4 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл 48,795.1 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 83.2 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **132,597,007.17** | **93,128,205.29** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 72,700,015.17 | 23,049,003.29 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 72,700,015.17 | 23,049,003.29 |
| **3121** | **Төгрөг** | 72,700,015.17 | 23,049,003.29 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 72,700,015.17 | 23,049,003.29 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 59,896,992.00 | 70,079,202.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 59,896,992.00 | 70,079,202.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,036,610.00 | 2,448,120.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 58,860,382.00 | 67,631,082.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **687,111,276.04** | **713,061,362.08** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 687,111,276.04 | 713,061,362.08 |
| **392** | **Биет хөрөнгө** | 685,111,276.04 | 711,061,362.08 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 617,367,447.38 | 617,367,447.38 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (41,506,326.53) | (47,602,976.45) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 86,537,222.00 | 106,436,722.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,338,043.19) | (25,574,643.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,511,503.60 | 56,078,769.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,513,031.10) | (13,896,815.13) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 21,852,500.00 | 21,752,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,799,996.12) | (5,499,641.94) |
| 39217 | Ном | 2,000,000.0 | 2,000,000.0 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 2,000,000.0 | 2,000,000.0 |
| 39301 | Программ хангамж | 250,000.00 | 250,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (250,000.0) | (250,000.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,000,000.0 | 2,000,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **819,708,283.21** | **806,189,567.37** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,267,876.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,267,876.00 | - |
| **413** | **Өглөг** | 1,267,876.00 | - |
| **41310** | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,267,876.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **816,440,407.21** | **804,189,567.37** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 816,440,407.21 | 804,189,567.37 |
| **511** | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 301,293,916.00 | 301,293,916.00 |
| **51101** | Өмч: - төрийн | 301,293,916.00 | 301,293,916.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 514,955,539.12 | 502,704,699.28 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 514,955,539.12 | 514,955,539.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (12,250,839.84) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 190,952.09 | 190,952.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **817,708,283.21** | **804,189,567.37** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **725,115,879.00** | **807,138,847.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **192,505,679.00** | **206,639,747.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 192,505,679.00 | 206,639,747.00 |
| **120004** | Төсөв байгууллагын өөрийн орлого | 115,114,957.00 | 151,689,747.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 115,114,957.00 | 151,689,747.00 |
| **120009** | Бусад орлого | 1,267,876.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 45,500,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 9,450,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **532,610,200.00** | **600,499,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 491,780,200.00 | 551,704,000.00 |
| **131001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 491,780,200.00 | 551,704,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 40,830,000.00 | 48,795,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 40,830,000.00 | 48,795,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **638,944,156.36** | **848,959,185.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **638,944,156.36** | **848,959,185.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 617,163,756.18 | 832,297,575.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 417,331,154.12 | 595,280,025.88 |
| 210101 | Үндсэн цалин | 271,072,859.92 | 355,451,658.25 |
| 210102 | Нэмэгдэл | 133,504,294.20 | 215,230,019.23 |
| 210104 | Урамшуулал | 12,754,000.00 | 24,598,348.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,291,377.00 | 69,477,309.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 40,318,191.00 | 47,248,953.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 4,743,400.00 | 5,596,575.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 2,371,600.00 | 2,772,697.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 2,371,591.00 | 2,772,697.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 9,486,595.00 | 11,086,387.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,165,599.82 | 34,448,139.32 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 4,396,239.82 | 5,068,879.32 |
| **210302** | Түлш, халаалт | 24,615,360.00 | 24,615,360.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 4,154,000.00 | 4,763,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,657,792.64 | 8,121,929.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 877,000.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,949,936.00 | 2,888,029.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,530,500.00 | 727,800.00 |
| 210409 | Бараа материал акталсны зардал | 5,300,356.64 | 4,506,100.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 67,487,730.00 | 61,342,616.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 556,500.00 | 200,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 66,931,230.00 | 61,142,616.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,684,000.00 | 3,646,050.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,684,000.00 | 3,646,050.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,560,500.00 | 2,095,393.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,560,500.00 | 2,095,393.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,985,602.60 | 57,886,112.92 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,930,175.00 | 3,795,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,672,700.00 | 4,311,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,382,727.60 | 49,779,412.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,780,400.18 | 16,661,610.68 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,800,000.00 | 5,314,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,800,000.00 | 5,314,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 11,347,510.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 11,347,510.68 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,980,400.18 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,980,400.18 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,048,876.64** | **(12,250,839.84)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **10,048,876.64** | **(12,250,839.84)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **648,993,033.00** | **752,188,847.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **116,382,833.00** | **151,689,747.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 116,382,833.00 | 151,689,747.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 115,114,957.00 | 151,689,747.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 115,114,957.00 | 151,689,747.00 |
| 120009 | Бусад орлого | 1,267,876.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **532,610,200.00** | **600,499,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 491,780,200.00 | 551,704,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 491,780,200.00 | 551,704,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 40,830,000.00 | 48,795,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 40,830,000.00 | 48,795,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **612,254,096.12** | **801,839,858.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **612,254,096.12** | **801,839,858.88** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **590,473,695.94** | **785,518,248.20** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 416,063,278.12 | 596,547,901.88 |
| **210101** | Үндсэн цалин | 269,804,983.92 | 355,451,658.25 |
| **210102** | Нэмэгдэл | 133,504,294.20 | 216,497,895.23 |
| **210104** | Урамшуулал | 12,754,000.00 | 24,598,348.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,291,377.00 | 69,477,309.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,318,191.00 | 47,248,953.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,743,400.00 | 5,596,575.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,371,600.00 | 2,772,697.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,371,591.00 | 2,772,697.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,486,595.00 | 11,086,387.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,165,599.82 | 34,448,139.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,396,239.82 | 5,068,879.32 |
| 210302 | Түлш, халаалт | 24,615,360.00 | 24,615,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,154,000.00 | 4,763,900.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 61,743,030.00 | 62,554,126.00 |
| **210502** | Хоол, хүнс | 61,743,030.00 | 62,554,126.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,684,000.00 | 2,999,450.00 |
| **210604** | Урсгал засвар | 2,684,000.00 | 2,999,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,560,500.00 | 2,095,393.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,560,500.00 | 2,095,393.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,965,911.00 | **16,395,929.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,293,211.00 | 12,089,929.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,672,700.00 | 4,306,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,780,400.18** | **16,661,610.68** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,800,000.00 | 5,314,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,800,000.00 | 5,314,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 11,347,510.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 11,347,510.68 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,980,400.18 | - |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,980,400.18 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **36,738,936.88** | **(48,991,011.88)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **495,000.00** | **660,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **495,000.00** | **660,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 495,000.00 | 660,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 495,000.00 | 660,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(495,000.00)** | **(660,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 36,243,936.88 | (49,651,011.88) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 72,700,015.17 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 72,700,015.17 | 23,049,003.29 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 303,293,916.0 | 190,952.09 | 428,783,816.48 | 732,268,684.57 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **303,293,916.0** | **190,952.09** | **428,783,816.48** | 732,268,684.57 |
| **Тайлант үеийн үр дүн** | - | - | 86,171,722.64 | 86,171,722.64 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **303,293,916.00** | **190,952.09** | **514,955,539.12** | 818,440,407.21 |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **303,293,916.00** | **190,952.09** | **514,955,539.12** | 818,440,407.21 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **303,293,916.00** | **190,952.09** | **514,955,539.12** | 818,440,407.21 |
| **Тайлант үеийн үр дүн** | - | - | (12,250,839.84) | (12,250,839.84) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **303,293,916.00** | **190,952.09** | **502,704,699.28** | 806,189,567.37 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 856,597,500.00 | 790,492,348.20 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 856,597,500.00 | 789,832,348.20 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 851,283,300.00 | 784,518,248.20 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 629,304,500.00 | 596,547,901.88 |
| **210101** | Үндсэн цалин | 375,232,200.00 | 355,451,658.25 |
| **210102** | Нэмэгдэл | 242,587,300.00 | 216,497,895.23 |
| **210104** | Урамшуулал | 11,485,000.00 | 24,598,348.40 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 78,146,700.00 | 69,477,309.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 53,035,500.00 | 47,248,953.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 6,277,800.00 | 5,596,575.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 3,138,900.00 | 2,772,697.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 3,138,900.00 | 2,772,697.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 12,555,600.00 | 11,086,387.00 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 52,386,200.00 | 34,448,139.32 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 13,028,800.00 | 5,068,879.32 |
| **210302** | Түлш, халаалт | 33,054,900.00 | 24,615,360.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 6,302,500.00 | 4,763,900.00 |
| **2105** | Нормативт зардал | 71,409,000.00 | 62,554,126.00 |
| **210502** | Хоол, хүнс | 71,409,000.00 | 62,554,126.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 2,999,450.00 |
| **210604** | Урсгал засвар | - | 2,999,450.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,516,600.00 | 2,095,393.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,516,600.00 | 2,095,393.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,520,300.00 | 16,395,929.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,214,300.00 | 12,089,929.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,306,000.00 | 4,306,000.00 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,314,100.00 | 5,314,100.00 |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 5,314,100.00 | 5,314,100.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,314,100.00 | 5,314,100.00 |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 660,000.00 |
| **2200** | Дотоод эх үүсвэрээр | - | 660,000.00 |
| **223001** | Бусад хөрөнгө | - | 660,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 856,597,400.00 | 752,188,847.00 |
| **1310** | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 618,169,700.00 | 551,704,000.00 |
| **131001** | Улсын төсвөөс санхүүжих | 618,169,700.00 | 551,704,000.00 |
| **1320** | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 52,386,200.00 | 48,795,100.00 |
| **132001** | Орон нутгийн төсвөөс | 52,386,200.00 | 48,795,100.00 |
| **120004** | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 186,041,500.00 | 151,689,747.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 186,041,500.00 | 151,689,747.00 |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 72,700,015.17 |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 23,049,003.29 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,497.1 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад 10,497.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- ✓ Үр дүнгийн тайлангийн бараа материал акталсан зардлыг 4,506.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь,
- ✓ Үр дүнгийн тайлангийн цалин хөлсний зардлыг цалингийн өглөгтэй тулган баталгаажуулахад 5,991.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь УСНББОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга*,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар 3 зөрчилд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Хоол, хүнсний зардлыг тогтоосон норм нормативаас 2,288.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", Монгол улсын Засгийн газрын 2024 оны "*Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай*" 237 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

### 5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: 1 Эд хариуцагч 69,114.4 мянган төгрөгийн хүнсний тайлан гаргаагүй, нягтлан бодогч материалын тайлангийн зарцуулалтыг бөөн дүнгээр тайлагнасан, үр дүнгийн тайланд тусгасан хоол хүнсний зардлын дүн нярвын тайлангаас 2,286.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*Үнэн зөв байх*", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*" гэсэн заалттай тус тус нийцээгүй .

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: 2 Санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар байгууллагын эд хариуцагч 69,114.4 мянган төгрөгийн хүнсний материалын тайлан гаргаагүй, нягтлан бодогч материалын тайлангийн зарцуулалтыг бөөн дүнгээр тайлагнасан, хагас жилээр хөрөнгийн тооллого хийгээгүй, хоол, хүнсний зардлыг тогтоосон норм нормативаас 2,288.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Албан үүргээ биелүүлээгүй цэцэрлэгийн эрхлэгчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *Залруулсан* | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайлангийн цалин хөлсний зардлыг цалингийн өглөгтэй тулган баталгаажуулахад 5,991.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 5,991.0 | | | 1 | 5,991.0 | 1 | 5,991.0 | | | | |
| Үр дүнгийн тайлангийн бараа материал акталсан зардлыг 4,506.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 4,506.1 | | | 1 | 4,506.1 | 1 | 4,506.1 | | | | |
| **ДҮН** | **1** | **10,497.1** | | | **1** | **10,497.1** | **1** | **10,497.1** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар байгууллагын эд хариуцагч 69,114.4 мянган төгрөгийн хүнсний материалын тайлан гаргаагүй, нягтлан бодогч материалын тайлангийн зарцуулалтыг бөөн дүнгээр тайлагнасан, хагас жилээр хөрөнгийн тооллого хийгээгүй, хоол, хүнсний зардлыг тогтоосон норм нормативаас 2,287.8 мяган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан | 1 | 0 | | | | | | | 1 | 0 | | |
| Эд хариуцагч 68,828.4 мянган төгрөгийн хүнсний тайлан гаргаагүй, нягтлан бодогч материалын тайлангийн зарцуулалтыг бөөн дүнгээр тайлагнасан, үр дүнгийн тайланд тусгасан хоол хүнсний зардлын дүн нярвын тайлангаас 2,286.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 69,114.4 | | | 1 | 69,114.4 | | | | | | |
| Хоол, хүнсний зардлыг тогтоосон норм нормативаас 2,288.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан | 1 | 2,288.0 | 1 | 2,288.0 | | | | | | | | |
| **Дүн** | **3** | **71,402.4** | **1** | **2,288.0** | **1** | **69,114.4** | | | **1** | **0** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 11,347.5 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 33,716.5 мянган төгрөгийн 5 орлогын гүйлгээг мэдээлээгүй, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл оруулаагүй байна. | 1 | 45,064.0 | | | 1 | 45,064.0 | | |
| **Дүн** | **1** | **45,064.0** | | | **1** | **45,064.0** | | |